

5. Номын сан буюу СУ-17 тайланг системээс хэрхэн гаргах зааварчилгаа

НОМЫН САН БУЮУ СУ-17 ТАЙЛАНГ СИСТЕМЭЭС ХЭРХЭН ГАРГАХ ЗААВАРЧИЛГАА

Номын сангийн мэдээлэл буюу СУ-17 тайлангийн мэдээллийг системээс хэрхэн гаргах зааварчилгааг өгнө. Дараах дэд бүлгээс тодруулан ойлголтыг авна уу.

- Номын сангийн асуулга бөглөх
- Тайланг гаргах

Зааварчилгаа

✓ Номын сангийн асуулга

Номын сангийн асуулга мэдээллийг оруулахад дараах дарааллыг баримтална. Үүнд:

1. Статистикийн удирдлага системийг сонгож орно.
2. **Номын сангийн асуулга** үйл ажиллагааг сонгоно.
3. **Номын сангийн асуулга** цонх дахь хүснэгтэн мэдээллийн талбарт асуултын дагуу тоон мэдээллийг оруулна.
4. **Хадгалах** товчийг дарна.

Статистик системийн үйл ажиллагааны жагсаалтаас **Номын сангийн асуулга**-г сонгоход дараах цонх нээгдэнэ. Цонхны ерөнхий бүтэц нь номын сангийн бүртгэлтэй холбоотой мэдээллийг агуулах бөгөөд мэдээллийг оруулж баруун дээд хэсэгт байрлах **Хадгалах** товч дарснаар

✓ **Мэдээллийг амжилттай хадгаллаа.** бичиглэл гарч хадгалагдана.

Номын сан

Статистик хяналт | Номын сан | Орчны асуулга | Урсгын шалгалт | Дрвшилт | Төгсөлт | Баримт бичиг | Дүрэмт хувцас

Номын сангийн асуулга 2018 - 2019 хичээлийн жил | Хадгалах

Үндсэн мэдээлэл

Номын сангийн тоо	1	Олгосон номын тоо	2,452
Суудлын тоо	16	Уншигчдын тоо	176

Номын фонд

Сурах бичгийн тоо	1,913	Бусад номын тоо	662
Сурах бичиг үнийн дүнгээр <u>/мян.төг/</u>	2,804.236 2804236.000 төг	Бусад ном үнийн дүнгээр <u>/мян.төг/</u>	7,333.05 7333050.00 төг

Шинээр авсан ном

Сурах бичгийн тоо	344	Бусад номын тоо	101
Сурах бичиг үнийн дүнгээр <u>/мян.төг/</u>	7,642.00 7642000.00 төг	Бусад ном үнийн дүнгээр <u>/мян.төг/</u>	2,060.244 2060244.000 төг

Фондоос хасагдсан ном

Сурах бичгийн тоо	144	Бусад номын тоо	115
Сурах бичиг үнийн дүнгээр <u>/мян.төг/</u>	3,331.713 3331713.000 төг	Бусад ном үнийн дүнгээр <u>/мян.төг/</u>	6,670.091 6670091.000 төг

АНХААРАХ ЗҮЙЛС:

- Асуулгын талбар дахь мэдээллийг буруу оруулсан бол засаж хадгалах үйлдэл хийнэ.
- Ном болон сурах бичгийн тоог оруулахдаа ширхэгээр, үнийн дүн (мян.төг)-ийн мэдээллийг мянган төгрөгөөр оруулах бөгөөд талбарт үнийн дүнг мянгачилж оруулахдаа оронг таслалаар биш цэгээр оруулна. Мянгачилж оруулсан таны мэдээллийг харгалзах талбарын ард системээс мөнгөн дүнг харуулж байгаа болно.

Жишээлбэл: 15 842 200 төгрөгийг талбарт 7,333.05 гэж цэгийг таслалаар, тоон утгыг
мянгачилж зөв оруулснаар талбарт 7,333.05 7333050.00 төг харагдана. (талбарын ард
мөнгөн дүнгээр харуулсан байна.)

✓ **Номын сангийн тайланг гаргах**

Номын сангийн тайлан (СУ17)-г гаргахдаа дараах зүйлсийг анхаарна. Үүнд:

- **Номын сангийн асуулгын мэдээллийг оруулсан, засаж өөрчилсний дараа заавал мэдээллийг шинэчлэх үйлдлийг хийнэ. Дараах дарааллын дагуу хийнэ.**
 - 1) *Статистикийн удирдлагын системийн Статистик хяналт* үйл ажиллагааны *Нэгтгэл* табын *Төлөв* дэд таб дахь **Тайлант хугацааны мэдээлэл** хэсгийн **номын сангийн мэдээллийн харгалзах мөрний Шинэчлэх**-д дарж номын сангийн асуулгын мэдээллийг шинэчилнэ. Хэрэв шинэ тайлангийн үе нээгдсэн бол хамгийн түрүүнд нэг удаа **Бүгдийг шинэчлэх** товчийг дарахыг анхаарна уу.
 - 2) *Статистикийн удирдлагын системийн Статистик хяналт* үйл ажиллагааны *Нэгтгэл* табын *Орчин* дэд таб дахь **Хяналт хэсэгт номын сангийн асуулгын мэдээллийг хариулсан эсэх мэдээллийг өгнө.**
Асуулгыг бөглөөгүй, талбаруудад тэг утга оруулсан бол хариулаагүй гэж үзнэ.
 - 3) *Статистикийн удирдлагын системийн Статистик хяналт* үйл ажиллагааны *Тайлан* табд тухайн тайлангийн хугацаанд гарах тайлангийн жагсаалт байх бөгөөд хэрэв номын сангийн мэдээллийг шинэчилсэн бол төлөв **Дахин бодуулах** төлөвт орох бөгөөд харгалзах мөрний **Бодох** товчийг дарснаар шинэчилсэн мэдээллээр тайланг системээр бодно.  товч дээр дарж СУ17 номын сангийн тайланг эхсэл хэлбэрээр харах боломжтой.
 - 4) Тайлан үнэн зөв гарсан гэж үзвэл **Илгээх** товчийг дарснаар хариуцсан мэргэжилтэнд мэдээлэл очиж, **илгээгдсэн** төлөвт орж мэдээлэл **шинэчлэх** боломжгүй болно. Тухайн тайлант хугацаанд гарч буй БДБ тайлангууд илгээх товчийг дарснаар нэг удаа зэрэг илгээгдэхийг анхаарна уу.